СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2026/113/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn<br>Сүхбаатар сум<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх<br>Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ц.Отгонбаяр<br>Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn<br>Аудитын гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК<br>Утас: 99052418 Цахим хаяг:B.Naranchimeg.POA@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХУШААТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Э.АРИУНАА ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/113/НА-СТА-ТШЗ
танай ____________-ны № ______________-т

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь аймгийн Боловсролын газраас 825.4 мянган төгрөгийн ном сурах бичиг, тоног төхөөрөмж, Боловсролын яамнаас 20,300.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж зэрэг 41,125.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 5 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 4 | **156,194,415.42** | **141,214,087.47** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 6 | **40,280,195.34** | **48,991,297.44** |
| 3542 | Аж ахуйн материал | | 8,264,578.34 | 17,458,017.44 |
| 3546 | Хүнсний материал | | 4,437.00 | 4,100.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | | 32,011,180.00 | 31,529,180.00 |
| I | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **196,474,610.76** | **190,205,384.91** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7 | **1,450,293,926.87** | **1,493,943,876.83** |
| 392 | **Биет хөрөнгө** | | **1,420,193,926.87** | **1,463,843,876.83** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 1,315,727,094.28 | 1,315,727,094.28 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | -226,506,697.92 | -239,165,490.06 |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | | 14,562,500.00 | 14,562,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | -14,562,500.00 | -14,562,500.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 315,496,546.40 | 344,484,546.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | -58,695,442.07 | -68,607,981.56 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 89,006,755.93 | 128,926,755.93 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | -37,141,144.71 | -39,890,038.22 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 15,972,100.00 | 15,972,100.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | -7,973,451.94 | -8,736,661.87 |
| 39217 | Ном | | 14,308,166.90 | 15,133,551.93 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | | **30,100,000.00** | **30,100,000.00** |
| 39301 | Программ хангамж | | 225,000.00 | 225,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | -225,000.00 | -225,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 30,100,000.00 | 30,100,000.00 |
| II | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,450,293,926.87** | **1,493,943,876.83** |
| III | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **1,646,768,537.63** | **1,684,149,261.74** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 9 | **80,559,221.43** | **83,955,045.67** |
| 413 | Өглөг | | 80,559,221.43 | 83,955,045.67 |
| IV | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **80,559,221.43** | **83,955,045.67** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 1,566,209,316.20 | 1,600,194,216.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 252,501,089.66 | 252,501,089.66 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | | **623,468,281.47** | **657,453,181.34** |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | | 623,468,281.47 | 623,468,281.47 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | | 33,984,899.87 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 690,239,945.07 | 690,239,945.07 |
| V | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **1,566,209,316.20** | **1,600,194,216.07** |
| VI | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **1,646,768,537.63** | **1,684,149,261.74** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **1,607,410,200.00** | **1,806,736,500.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | 1,396,265,500.00 | 1,637,132,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,396,265,500.00 | 1,637,132,700.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | | 211,144,700.00 | 169,603,800.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 211,144,700.00 | 169,603,800.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | | |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **86,838,944.00** | **49,692,116.13** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 86,838,944.00 | 49,692,116.13 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 10,210,000.00 | 1,670,392.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 10,210,000.00 | 1,670,392.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 210,000.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 72,107,570.60 | 41,125,385.03 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 4,521,373.40 | 6,896,339.10 |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2** | **1,694,249,144.00** | **1,856,428,616.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,593,222,410.49** | **1,822,443,716.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **1,560,727,910.49** | **1,773,850,189.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **1,049,507,617.46** | **1,296,853,972.22** |
| 210101 | Үндсэн цалин | | 646,057,398.81 | 775,688,402.93 |
| 210102 | Нэмэгдэл | | 370,360,353.65 | 464,402,081.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | 38,727,971.24 |
| 210104 | Урамшуулал | | 33,089,865.00 | 18,035,516.09 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **129,859,588.54** | **163,515,545.07** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 87,886,747.42 | 112,774,957.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 11,152,683.72 | 13,238,359.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 5,351,089.73 | 6,651,823.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 5,160,444.19 | 6,091,719.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 20,308,623.48 | 24,758,684.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **164,338,542.77** | **165,278,170.88** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 9,685,802.77 | 10,674,630.88 |
| 210302 | Түлш, халаалт | | 149,652,740.00 | 149,603,540.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **36,794,000.00** | **48,716,400.00** |
| 210502 | Хоол,хүнс | | 36,794,000.00 | 48,716,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **22,360,000.00** | **4,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | | 22,360,000.00 | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **16,726,054.47** | **30,582,646.67** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 16,726,054.47 | 30,582,646.67 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **141,142,107.25** | **64,903,455.07** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 44,170,530.00 | 31,154,460.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 9,767,600.00 | 7,665,560.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 87,203,977.25 | 26,083,435.07 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **32,494,500.00** | **48,593,526.35** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 32,494,500.00 | 48,593,526.35 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 32,494,500.00 | 47,969,500.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | 624,026.35 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3** | **111,426,733.51** | **1,822,443,716.26** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 632,508.22 | |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | - 632,508.22 | |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **110,794,225.29** | **33,984,899.87** |

1324100015 9055436

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,628,020,200.00** | **1,808,406,892.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,210,000.00** | **1,670,392.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 10,210,000.00 | 1,670,392.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,617,810,200.00** | **1,806,736,500.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,396,265,500.00 | 1,637,132,700.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 211,144,700.00 | 169,603,800.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,548,635,096.81** | **1,794,779,219.95** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,516,139,625.81** | **1,747,920,980.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,049,334,686.80** | **1,297,026,902.88** |
| 210101 | Үндсэн цалин | 645,884,468.15 | 775,861,333.59 |
| 210102 | Нэмэгдэл | 370,360,353.65 | 464,402,081.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 38,727,971.24 |
| 210104 | Урамшуулал | 33,089,865.00 | 18,035,516.09 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **129,859,588.54** | **163,515,545.07** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,886,747.42 | 112,774,957.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,152,683.72 | 13,238,539.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,351,089.73 | 6,651,823.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,160,444.19 | 6,091,719.41 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,308,623.48 | 24,758,684.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **198,144,700.00** | **165,979,773.65** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,984,200.00 | 11,376,233.65 |
| 210302 | Түлш, халаалт | 184,160,500.00 | 149,603,540.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **36,797,466.00** | **45,441,400.00** |
| 210502 | Хоол,хүнс | 36,797,466.00 | 45,441,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **22,360,000.00** | **3,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 22,360,000.00 | 3,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **16,726,054.47** | **27,479,027.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,726,054.47 | 27,479,027.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **62,917,130.00** | **45,478,332.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,403,130.00 | 36,608,572.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,514,000.00 | 8,869,760.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **32,495,471.00** | **46,858,239.35** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 32,495,473.00 | 46,234,213.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 624,026.35 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **79,385,103.19** | **13,627,672.05** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **32,501,312.00** | **28,608,000.00** |
| | Дотоод эх үүсвэрээр | 32,501,312.00 | 28,608,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-32,501,312.00** | **-28,608,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **46,883,791.19** | **-14,980,327.95** |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **156,194,415.42** |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **141,214,087.47** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 10 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **252,501,089.66** | **690,239,945.07** | **623,468,281.47** | **1,566,209,316.20** |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 33,984,899.87 | 33,984,899.87 |
| 18 | ................... | | | | |
| 19 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **252,501,089.66** | **690,239,945.07** | **657,453,181.34** | **1,600,194,216.07** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО** | **1,971,099,487.00** | **1,821,162,801.60** | **149,936,685.40** | **92.4** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,801,495,687.00 | 1,652,183,027.95 | 149,312,659.05 | 91.7 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,645,300,271.58 | 1,652,183,027.95 | -6,882,756.37 | 100.4 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | 156,195,415.42 | | 156,194,415.42 | |
| **132** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **169,603,800.00** | **168,979,773.65** | **624,026.35** | **99.6** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 169,603,800.00 | 168,979,773.65 | 624,026.35 | 99.6 |
| **1200042** | **Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих** | **1,670,392.00** | **1,600,392.00** | **70,000.00** | **95.8** |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,972,769,879.00** | **1,822,763,193.60** | **150,006,685.40** | **92.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,972,769,879.00** | **1,822,763,193.60** | **150,006,685.40** | **92.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,925,404,800.00** | **1,776,528,980.60** | **148,875,819.40** | **92.3** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,419,576,000.00** | **1,297,026,902.88** | **122,549,097.12** | **94.7** |
| 210101 | Үндсэн цалин | 871,196,500.00 | 775,861,333.59 | 95,335,166.41 | 89.1 |
| 210102 | Нэмэгдэл | 529,823,700.00 | 464,402,081.96 | 65,421,618.04 | 93.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 38,727,971.24 | 38,727,971.24 | |
| 210104 | Урамшуулал | 18,555,800.00 | 18,035,516.09 | 520,283.91 | 97.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **178,657,000.00** | **163,515,545.07** | **15,141,454.93** | **91.5** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 121,486,700.00 | 112,774,957.96 | 8,711,742.04 | 92.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,292,600.00 | 13,238,359.25 | 1,054,240.75 | 92.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,146,300.00 | 6,651,823.90 | 494,476.10 | 93.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,146,300.00 | 6,091,719.41 | 1,054,580.59 | 85.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,585,100.00 | 24,758,684.55 | 3,826,415.45 | 86.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **166,603,800.00** | **165,979,773.65** | **624,026.35** | **99.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,000,000.00 | 11,376,233.65 | 623,766.35 | 94.8 |
| 210302 | Түлш, халаалт | 149,603,800.00 | 149,603,540.00 | 260.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,000,000.00 | 5,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **45,441,400.00** | **45,441,400.00** | **0** | **100.0** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,000,000.00** | **3,000,000.00** | **0.00** | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **27,877,300.00** | **27,479,027.00** | **398,273.00** | **98.6** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 110,000.00 | 0.00 | 110,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 27,767,300.00 | 27,479,027.00 | 288,273.00 | 99.0 |

1324100015 9055436

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **84,249,300.00** | **74,086,332.00** | **10,162,968.00** | **87.9** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,348,500.00 | 65,216,572.00 | 10,131,928.00 | 86.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,900,800.00 | 8,869,760.00 | 31,040.00 | 99.7 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **47,365,079.00** | **46,234,213.00** | **1,130,866.00** | **98.0** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 47,365,079.00 | 46,234,213.00 | 1,130,866.00 | 98.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 47,365,079.00 | 46,234,213.00 | 1,130,866.00 | 98.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **1,972,769,879.00** | **1,822,763,193.60** | **150,006,685.40** | **92.4** |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 156,194,415.42 | -156,194,415.42 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 142,214,087.47 | -141,214,087.47 | |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | 100.0 |
| 5 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 47 | 47 | | 100.0 |
| 6 | Удирдах ажилтан | 4 | 4 | | 100.0 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 22 | 22 | | 100.0 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 21 | 21 | | 100.0 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **698,407.5** мянган төгрөгийн дараах алдааг залруулалаа. Үүнд:

- ТАЦНС-ээр бодогдсон цалинг санхүүгийн тайлангийн Си Ти Эс программд шууд татуулахгүйгээр гараар оруулахдаа бичилтийг дүн зөрүүтэй буруу хийснээр цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ, ажиллагсадтай хийх тооцооны дансууд зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө хэсэгт орлогыг 8,167.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 690,239.9 мянган төгрөгийг тусгаагүй;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандарт болон “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 531.5 мянган төгрөгийн илэрч албан шаардлага хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 531.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Үдийн цай хөтөлбөрийн зардлаас 531.5 мянган төгрөгийг дотуур байрны хоолны зардалд бүлэг хооронд гүйлгэн зарцуулж гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"* гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

<u>**Шийдвэрлэсэн нь:**</u> Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй, орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэлэс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТАЦНС-ээр бодогдсон цалинг санхүүгийн тайлангийн Си Ти Эс программд шууд татуулахгүйгээр гараар оруулахдаа бичилтийг дүн зөрүүтэй буруу хийснээр цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ, ажиллагсадтай хийх тооцооны дансууд зөрүүтэй илэрхийлэгдсэн | 1 | | 1 | | | | 1 | | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө хэсэгт орлогыг | 1 | 8,167.6 | | | 1 | 8,167.6 | 1 | 8,167.6 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| зөрүүтэй илэрхийлсэн; | | | | | | | | | | | | |
| Санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг тусгаагүй; | 1 | 690,239.9 | 1 | 690,239.9 | | | 1 | 690,239.9 | | | | |
| **Дүн** | 3 | 698,407.5 | 2 | 690,239.9 | 1 | 8,167.6 | 3 | 698,407.5 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үдийн цай болон дотуур байрны хоолны зардлыг гүйлгээн зарцуулсан боловч бодитоор тайлагнаагүй | 1 | 531.5 | | | 1 | 531.5 | | | | | | |
| Дүн | 1 | 531.5 | | | 1 | 531.5 | | | | | | |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | 1 | | | |